

ИОНН-ын ээлжит бус их хурлын 2024 оны 11 сарын

16-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Дүрэм, дүрмийн зорилт

- 1.1 Энэхүү Иргэдийн Оролцооны Нэгдэл намын дүрэм (цаашид “**Намын дүрэм**” гэх)-ийг Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон холбогдох бусад журамтай нийцүүлэн боловсруулж, дүрмийн төсөлд Намын үүсгэн байгуулагч гишүүдийн саналыг авч улмаар ИОНН үүсгэн байгуулах хурлаар танилцуулж, баталсан болно.
- 1.2 Намын дүрмээр Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд тус намд элсэх, намын гишүүнээс түдгэлзүүлэх, гарах, гишүүдийн эрх үүргийг тогтоох, намын үйл ажиллагааг удирдах бүтэц зохион байгуулалтыг байгуулах, намын үйл ажиллагааг төлөвшүүлэх хийгээд намын дотоод бүртгэл, гишүүний татвар, хандив, дотоод хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.3 Иргэдийн Оролцооны Нэгдэл нам нь (цаашид ИОНН эсхүл Нам гэх)
 - 1.3.1 Тодорхойлолт: Иргэдийн Оролцооны Нэгдэл нам нь Монгол улсын тусгаар тогтнол, бие даасан урт хугацааны тогтвортой хөгжлийг иргэдийн идэвхтэй оролцоо, эрх, эрх чөлөөний тусламжтайгаар буй болгож баталгаажуулах зорилго бүхий, баруун төвийн үзэл санааг баримталсан Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн чөлөөт, сайн дурын нэгдэл юм.
 - 1.3.2 Намын албан ёсны нэрийг бүтнээр “Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам” гэх ба “ИОНН”, эсхүл “ИОН Нам” гэж товчилно. Англиар “The Civic Unity Party” гэх ба “CUP” гэж товчилно.
 - 1.3.3 Иргэдийн Оролцооны Нэгдэл намын бэлгэдэл нь мөнх тэнгэрийг харуулсан цэнхэр дэвсгэр дээр Монгол орны дөрвөн зүг, найман зовхисоос иргэд эрх чөлөөтэй, эвлэлдэн нэгдэж эх орондоо хөгжил дэвшил авчирч, дээшлэн дэвжиж байхыг цагаан өнгийн гар гараасаа хөтлөлцсөн найман хүний дүрээр харуулж, иргэдийнхээ идэвхтэй оролцоогоор өнөд хамгаалагдаж бэхжих тусгаар тогтнол, төрт ёс, хууль ёсыг төвдөө алтан тойрогт залрах соёмбо тэмдгээр илэрхийлэн дүрсэлсэн байна.
 - 1.3.4 Иргэдийн Оролцооны Нэгдэл намын далбаа нь хэмжээнийхээ гуравны нэгийг эзэлсэн төв хэсэгт ИОНН-ын бэлгэдлийг багтаасан цэнхэр өнгөтэй байна. Далбааг хэвтээ болон босоо хэлбэрээр хэрэглэж болох бөгөөд аль ч тохиолдолд бэлгэдлийн төв хэсэгт байрлах алтан соёмбо нь дээш харсан байна.
 - 1.3.5 Намын домэйн нэр нь www.cup.mn байна.

- 1.4 Намын нэр, далбаа, бэлгэдэл, домэйн нэр нь холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн буюу баталгаажсан даруйдаа намын оюуны өмч болно. Тэдгээрийн эх загварыг энэхүү Дүрмийн Хавсралт 1-д заав.
- 1.5 Нам нь өөрийн бэлгэдлийг дүрсэлсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр болон бэлгэдэл бүхий лого, тэмдэгтэй байна.
- 1.6 Энэхүү Намын дүрэмд үндэслэн Намын дүрэм хэрэгжүүлэх журмыг Төлөөлөгчдийн Танхим батална.
- 1.7 ИОНН нь дүрмээ баррель үсгээр хэвлүүлнэ. Сонсдог хэлбэрээр нийтэлнэ.
- 1.8 Энэхүү дүрмийн аль ч зүйл хэсгийг мушгин тайлбарлахгүй бөгөөд дараах хэм хэмжээний дэс дарааллыг баримтална. Үүнд:
 - 1.8.1 Намын үзэл баримтлал, үнэт зүйл;
 - 1.8.2 Үйл ажиллагааны зарчим;
 - 1.8.3 Намын дүрмийн тухайлсан зохицуулалт;
 - 1.8.4 Төлөөлөгчдийн танхимаар баталсан журам.

2 дугаар зүйл. Намын үзэл баримтлал, үнэт зүйл.

- 2.1 Иргэдийн Оролцооны Нэгдэл нам нь баруун төвийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэгч нам болохын хувьд дараах үнэт зүйлтэй байна. Үүнд:
 - 2.1.1 Монгол Улсын аюулгүй байдал, бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол бол ИОНН-ын нэн тэргүүний язгуур үнэт зүйл мөн.
 - 2.1.2 Ардчилал, олон намын тогтолцоо, парламентын засаглал, хүний эрх, эрх чөлөө нь ИОНН-ын тууштай хамгаалах ёстой үнэт зүйл мөн.
 - 2.1.3 Хувийн өмч, хувийн хэвшил нь улс орны эдийн засгийн хамгийн тогтвортой бат бэх үндэс бөгөөд эдийн засгийн чөлөөт байдалд төрийн оролцоо хязгаарлагдмал байх бодлогыг баримтална.
 - 2.1.4 Үндэсний өв соёлоо хамгаалж судлах, өвлөн тээх, дамжуулан уламжлуулах, орчин үеийн Монгол үндэсний бахархал, соёлыг бүтээлцэх нь ИОНН-ын гишүүн бүрийн эрхэмлэх үнэт зүйл мөн.
 - 2.1.5 Ил тод байдал, иргэний оролцоо, хэмнэлттэй байдал, улс төрийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ нь ИОНН-ын гишүүн бүрийн болон намын үйл ажиллагааны үнэт зүйл мөн.
 - 2.1.6 Хуулийн засаглалыг хөгжүүлэн бэхжүүлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, улс орны тогтвортой хөгжлийг бий болгох, Монгол оронд хүн шударгаар ажиллаж амжилтад хүрч, аз жаргалтай амьдарч болох хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлоох нь бидний үнэт зорилт мөн.
 - 2.1.7 Гадаад харилцаанд олон талт, энх тайванч, найрсаг хөршийн бодлогыг тууштай дэмжиж, бусад улс төрийн намуудтай гадаад харилцааны асуудлаар зөрчилдөхөөс сэргийлж, Монгол Улсын нэгдмэл гадаад бодлогыг баталгаажуулах нь намын үнэт зүйл мөн.

- 2.1.8 Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын суурь үйлчилгээг зорилтот бүлэгт оновчтой хүргэх, үр нөлөөг дээшлүүлэх, нийгмийн олон талт асуудлаар нийтийн боловсролыг байнга нэмэгдүүлэх замаар ирээдүйн зардлыг бууруулах нь намын бодлогын чухал хэсэг мөн.
- 2.1.9 Уламжлалт мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, аялал жуулчлал зэрэг олон салбарын суурь нь болсон байгаль орчин, бэлчээр, ус, ой, газрын баялагтай холбоотой аливаа чиглэлд ИОНН тогтвортой хөгжил, хариуцлагатай хэрэглээ, ил тод байдал, нийтийн эрх ашиг - хувийн өмчийн эрхийн тэнцвэртэй харилцаа, ирээдүйд үлдээх нөөц, нөхөн сэргээлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх явдлыг үнэт зүйл гэж үзнэ.
- 2.1.10 Нийгмийн харилцааны бүхий л оролцогчдын хөгжих, хөгжлийн үйл явцад оролцох боломжийг нэмэгдүүлэх, тэдний амьдрах орчныг эрүүл аюулгүй байдлыг сайжруулах нь ИОНН-ын үнэт зүйл мөн.
- 2.1.11 Нам нь эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эрх, үүрэг, боломж эдлүүлнэ.
- 2.1.12 Үзэл бодлоо илэрхийлэх үйл ажиллагааг зохистой арга хэлбэрээр зохион байгуулж, нийгмийн дэг журам, аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахыг эрхэмлэнэ.
- 2.1.13 Намын дотоод сонгуулийг нээлттэй, тэгш шударга зохион байгуулна.

3 дугаар зүйл. Намын үйл ажиллагааны зарчим

- 3.1 Нам үйл ажиллагаандаа дараах нийтлэг зарчмыг баримтална:
 - 3.1.1 ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх;
 - 3.1.2 үйл ажиллагаагаа ил тод явуулах;
 - 3.1.3 гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, аливаа сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох;
 - 3.1.4 дотоод асуудлаа шийдэхдээ нийтийн зарыг хүртээмжтэйгээр түгээж, хурал, сонгуульд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх;
 - 3.1.5 бусад намын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс үл оролцох, өөрийн үзэл баримтлалыг тулган шаардахгүй байх;
 - 3.1.6 үйл ажиллагаагаа нутаг дэвсгэрийн зарчмаар явуулах;
 - 3.1.7 Монгол Улсаас гадаад улстай тогтоосон найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг эрхэмлэн хүндэтгэх.
 - 3.1.8 ИОНН нь оюуны өмч, оюуны бүтээлийг ямагт хүндэтгэн үйл ажиллагаандаа албан ёсны лиценз зөвшөөрөлтэй бараа бүтээгдэхүүн, программ, үйлчилгээг хэрэглэнэ. Үүнд намын хөрөнгөөс зарцуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ авах тухай хуулийн дагуу нээлттэй ил тод зохион байгуулна.

3.1.9 ИОНН нь орчин үеийн мэдээллийн технологийн шийдэл, гар утас болон таблетын аппликэйшн, вэбсайт, цахим шууданг өдөр тутмын үйл ажиллагаанд өргөнөөр хэрэглэж, гишүүдийн оролцоог орон зай, газар зүйн байрлалаас үл хамааран хүртээмжтэй зохион байгуулна. Эдгээр технологийг ашиглан гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрнө.

4 дүгээр зүйл. Намд элсэх, намаас гарах, түдгэлзэх

4.1 ИОНН нь гишүүдийнхээ өмнө гаргах баталгаа:

4.1.1 Иргэдийн Оролцооны Нэгдэл намд эвлэлдэн нэгдсэн, Намын үйл хэргийг олон нийтэд таниулахаар ажилласны төлөө болон гишүүний хувьд иргэнийг мөшгөн хавчих, заналхийлэх, гүтгэх, доромжлох, дарамтлах зэргээр хууль бус үйлдэл гаргасан бол ИОНН-ын энэ дүрэмд заасан бүтцийн байгууллага, албан тушаалтан гишүүнийхээ эрхийг хамгаалж, мэдэгдэл гаргана.

4.1.2 Намын гишүүний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ИОН Намын гишүүн болох талаар тодорхойлолтыг хэнд ч гаргахгүй. Гэхдээ Намын гишүүдэд нээлттэй аппликэйшн, вэбсайт, намын дотоод бүртгэлийн мэдээлэл үүнд хамаарахгүй.

4.1.3 Намын гишүүнийг бодлого, зарчим баримтлах, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн өрсөлдөөнд оролцох зэрэг улс төрийн эрхээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан аливаа шийтгэл хүлээлгэхгүй. Намын албан тушаалаас огцруулах, үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, хариуцлага тооцох нь зөвхөн энэ Намын дүрэм, түүний хүрээнд баталсан журмаар заасан хэм хэмжээний хүрээнд байна.

4.2 Монгол Улсын сонгуулийн насны эрх бүхий иргэн сайн дураар ИОНН-д өөрөө элсэнэ. Намд элсэхдээ дараах бүртгэлийн аль ч хэлбэрээр бүртгүүлж болно. Үүнд:

4.2.1 Цахим орчинд байрлах Намын албан вэбсайтад нийтлэгдсэн намын аппликэйшнийг ашиглаж бүртгэлийн өргөдлийг зааврын дагуу бөглөж илгээх, эсхүл

4.2.2 Өөрийн оршин суугаа газрын байрлалаас үл хамааран намын гүйцэтгэх байгууллага оршин байгаа байранд биеэр ирж бичгээр өргөдөл гаргах.

4.3 Цахимаар буюу өөрийн биеэр ирж өргөдөл гаргасны дагуу ИОНН-ын бүртгэгч (цаашид **Бүртгэгч** гэх) өргөдлийг системд оруулан намын аппликэйшн дээр дахин давтагдашгүй хувийн код үүсгэж, намын гишүүний цахим профайл үүссэнээр тухайн өргөдөл гаргагч ИОНН-д элссэнд тооцогдоно.

4.4 Өөр намын гишүүнийг ИОНН-д гишүүнээр бүртгэхгүй. Хэрэв Намд шинээр бүртгүүлсэн хүн өөр намын гишүүнээс гарах өргөдлөө тус намын төв буюу, эсвэл орон нутгийн харьяаллын анхан, дунд аль нэг шатны байгууллагад цахимаар илгээх буюу биечлэн хүлээлгэн өгсөн бол тус өдрөөс эхлэн шинээр бүртгүүлсэн хүнийг ИОНН-д элссэн гэж үзэн Намын үйл ажиллагаанд оролцох оролцоог гишүүний эрх, үүргийн дагуу тооцно.

4.5 ИОН Намын гишүүнээр элссэн хүн өөр намын бүртгэлээс хасагдсан эсэхээс үл хамааран тухайн намаас гарах өргөдлөө өгсөн огноогоор тооцож ИОН Нам шинэ гишүүн гэж үзнэ. ИОН Намаас гарах өргөдөл өгсөн хүнд энэ зарчим бас хамаарах бөгөөд намын бүртгэлээс хасагдсан эсэхээс үл хамааран өргөдөл гаргагчийг өргөдөл гаргасан өдрөөс ИОНН-аас гарсан гэж үзнэ.

4.6 Хуульд заасны дагуу төрийн зарим албан хаагчийн намын гишүүнчлэлийг түдгэлзүүлж болно. ИОН Намын гишүүн төрийн жинхэнэ албан хаагчаар томилогдсон өдрөөс намын

гишүүнчлэлийг түдгэлзүүлж намын цахим бүртгэлд түүнийг “идэвхигүй” хэлбэрт шилжүүлнэ.

4.7 Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын гишүүнийг хасах үндэслэлийг эрх бүхий бүтцийн байгууллагаас тогтоосон тохиолдолд Үнэт Зүйлийн Зөвлөлийн шийдвэрийн дагуу Бүртгэгч системээс хасна. Үүнд:

4.7.1 Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгын аливаа үйл ажиллагаанд ИОНН-ын нэр, туг, билэг тэмдгийг ашигласан;

4.7.2 Намын аль нэг бүтэц, удирдлагын сүлжээ, гишүүдийн баг бүрэлдэхүүнийг шашны, цэргийн, цэрэгжсэн байгууллага болгохыг завдсан;

4.7.3 Фашист үзэл санааг дэмжиж сурталчилсан бол тус тус намаас хасах үндэслэл болно.

4.7.4 Дээрх үйлдэлд хуулийн хариуцлага хүлээх бол тухайн асуудал шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл гишүүнчлэлийг түдгэлзүүлнэ.

4.8 Намын гишүүн хэдийд ч сайн дураар Намаас гарч болно. Намаас гарахдаа:

4.8.1 Намын Бүртгэгчийн албан ёсны цахим шуудангийн хаяг руу өөрийн цахим хаягнаас гараар бичсэн өргөдлийг илгээх, эсхүл

4.8.2 Оршин суугаа газрын байрлалаас үл хамааран намын албан ёсны хаяг бүхий аль ч байранд биеэр ирж гараар бичсэн өргөдлийг гаргана.

4.9 Энэ дүрмийн 4.8.1 болон 4.8.2-т заасан өргөдлийг намын Бүртгэгчийн цахим шуудангийн хаяг руу илгээснээр, эсхүл намын төв болон орон нутгийн аливаа салбарын удирдлагад бичгээр хүлээлгэн өгснөөр намаас гарсанд тооцогдоно.

4.10 Намаас гарсан тухай мэдээллийг өргөдөл хүлээн авсан намын хариуцлагатай албан тушаалтан намын мэдээллийн санд тэр даруй оруулахаар Бүртгэгчид илгээх ба зөвхөн Бүртгэгч гишүүний мэдээллийг намын бүртгэлээс хасалт хийнэ.

4.11 Намын Бүртгэгчийн албан ёсны цахим шуудангийн хаягаар намаас гарах өргөдлийг хүлээн авсан бол гишүүний харьяалагдаж буй салбар, төлөөлөгчийн танхимд хариуцаж буй дарга нарт мэдэгдэнэ.

4.12 Намын гишүүнээр элсээгүй Монгол улсын иргэн намын дэмжигч байж болно. Намын дэмжигч нь намын гишүүдийн нээлттэй уулзалт, сургалт, үйл ажиллагаанд хамрагдах, намын хуралд ажиглагчаар оролцох эрхтэй. Намын дэмжигч нь намын орон нутгийн салбар байгууллагад бүртгэлтэй байж болно.

5 дугаар зүйл. Намын гишүүн, түүний төрөл, эрх үүрэг

5.1 Намын гишүүд өөрийн нэрээр элсэж, өөрийн нэрийн өмнөөс Намын үйл хэрэгт оролцоно.

5.2 Намын гишүүн бүр энэхүү Намын дүрмийг зөвшөөрч, дагаж мөрдөх үүрэгтэй.

5.3 Намын гишүүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, намын үйл ажиллагаанд тэгш оролцох, намын бүтцийн байгууллагад сонгож, сонгогдох эрхтэй ба намын татвар төлөх,

хууль тогтоомж болон намын дүрэмд захирагдах, намын дүрэм журмаар тогтоосон бусад үүргийг биелүүлэх үүрэгтэй.

- 5.4 Намын гишүүн энэ дүрмийн 5.3-т заасан татвар төлөх үүргийг биелүүлэхээс түдгэлзэж намын “ажиглагч гишүүн” болж болно. Ажиглагч гишүүн нь намын гишүүний жилийн татварын хэмжээ 0-ээс дээш төгрөгөөр тогтоогдсон нөхцөлд татвар төлөөгүй хугацаандаа намын хуралд санал таслах эрхгүй байх бөгөөд харин намын бүтцийн байгууллагад сонгогдох, намын үйл ажиллагаанд тэгш оролцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь байнга хадгалагдана.
 - 5.5 Намын гишүүн тухайн жилийн татвараа төлсөн бол тухайн календарийн жилд “татвар төлөгч гишүүн” статустай байх бөгөөд намын аливаа хуралд татвар төлөгч гишүүн санал таслах эрхтэй байна. Хэрэв тухайн календарийн жил намын нийт гишүүдийг татвараас чөлөөлсөн, намын татварын хэмжээг “0”-тэй тэнцүү хэмжээгээр тогтоосон бол намын бүх гишүүд татвар төлөгч гишүүний эрхийг эдэлнэ.
 - 5.6 Намын гишүүн нь жилийн татвараас гадна, намын дансанд хандив өгсөн бол хандив өгсөн календарийн жилийн хугацаанд “хандивлагч гишүүн” гэж тооцогдоно.
 - 5.7 Хандивлагч гишүүн нь энэхүү дүрмийн 5.3-т заасан гишүүний эрхээс гадна зөвхөн хандивлагч гишүүдийн дунд явагдах санал асуулгад оролцох эрхтэй байна.
 - 5.8 Тухайн жилийн гишүүний татварын хэмжээнээс илүү хандив өгсөн хандивлагч гишүүн бүр татвар төлөгч гишүүн гэж тооцогдоно.
 - 5.9 Намын ажиглагч, татвар төлөгч, хандивлагч гишүүд нь улс төрийн сонгуульд нэр дэвшихээр бэлтгэж буй бол улс төрийн зорилготой хуримтлалын нэрийн данстай байх ба нэрийн хуримтлалын дансаа Бүртгэгчид бүртгүүлсэн гишүүнийг хуримтлал бүрдүүлэгч гишүүн гэнэ.
 - 5.10 Хуримтлал бүрдүүлэгч гишүүн нь намд өөрийн хуримтлалын 1 хувиас илүүгүй, хөдөлмөрийн хөлсний сарын доод хэмжээний 60 хувиас хэтрэхгүй хэмжээгээр жилд нэг удаа “хуримтлалын татвар” төлсөн бол энэ дүрмийн 5.3, 5.5-д заасан эрх, үүргээс гадна төрийн улс төрийн албан тушаал, сонгуульд намаас нэр дэвшигчийг бэлтгэх сургалт, шалгаруулалт, тандалт үнэлгээнд хамрагдах эрхтэй.
- 6 дугаар зүйл. Намд хориглох зүйлс, Намын гишүүний болон төрийн албан хаагчийн үүргийг зааглах**
- 6.1 Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэний намд албадан элсүүлэх болон намаас гарахыг шаардах, шахалт үзүүлэхийг хориглоно.
 - 6.2 ИОНН нь төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаанд хутгалдан оролцохыг хориглоно.
 - 6.3 ИОНН хамт олон дунд хөгжиж төрийн жинхэнэ албан хаагч болсон аливаа ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ хуулийг чанд баримтлах бөгөөд албан тушаалынхаа эрх мэдлийг аль нэгэн намын, тэр тусмаа өөрийн харьяалагдаж байсан энэхүү намын эрх ашигт нийцүүлэн ашиглахыг хориглоно.
 - 6.4 ИОНН-аас нэр дэвшин сонгогдсон, томилогдсон төрийн жинхэнэ албан хаагч өөрийн албан тушаалын хүрээнд хамаарах албан үүрэг гүйцэтгэхдээ намын эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргах, сурталчилгаа хийх, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд оролцохыг хориглоно.

- 6.5 ИОНН нь шашны байгууллагын үйл ажиллагаанд болон боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаанд оролцохгүй. Гэхдээ Намын гишүүн шашин шүтэх эс шүтэх, эрхээ эдлэхэд энэ заалт хамаарахгүй.
- 6.6 Хуулиар хориглосон этгээдээс хандив авахыг хориглоно.
- 6.7 Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгоор, түүнчлэн шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист нам байгуулахыг, фашист намтай нэгтгэх, нийлэхийг хориглоно.
- 6.8 Намын удирдлага, санхүүгийн албаны дарга, ерөнхий менежер, түүнтэй адилтгах албан тушаалтан нь аль нэгэн улс төрийн сан, нийгэмлэг, аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн нөөц захиран зарцуулах эрх бүхий албан тушаал эрхлэхийг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

НАМЫН САЛБАР, ТАНХИМ, НАМЫН ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГА, АЖЛЫН АЛБА БАЙГУУЛАХ

7 дугаар зүйл. Намын анхан шатны салбар, дунд шатны танхим байгуулах

- 7.1. Намын анхан шатны салбар байгуулахыг хүссэн ИОНН-ын гишүүн аль нэг сум, хороонд бүртгэлтэй гишүүдийн нэрсийн жагсаалтыг, дунд шатны танхим байгуулахыг хүссэн сум, хорооны салбарын дарга, эсхүл намын Төлөөлөгчдийн танхимын аль нэг гишүүн тухайн орон нутагт байгуулагдсан бүх анхан шатны салбарын танхимын гишүүдийн нэрсийг тус тус Бүртгэгчээс авч, салбар, танхим үүсгэн байгуулах хурлын байр эсхүл цахим хурлын линк, өдөр, цагийг товлосон зарыг хурал болохоос 24 цагаас багагүй хугацааны өмнө Бүртгэгчээс хүлээж авсан жагсаалт дахь нийт гишүүдэд хүргэнэ.
- 7.2. Дараах шаардлагыг хангасан бол дор дурдсан этгээд нутаг дэвсгэрийн харьяаллаар намын салбарыг сум, хороонд байгуулж болно. Үүнд:
 - 7.2.1. Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын сум, хорооны салбарыг тухайн сум, хороонд 10-аас доошгүй тооны иргэн намын аппликэйшн татаж энэ дүрмийн 5.1 дэх шаардлагыг хангаж бүртгүүлсэн бол намын гишүүний санаачилсан салбар байгуулах хурлаар дараах нууц санал хураалтыг явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.
 - 7.2.1.1. Намын сум, хорооны салбар байгуулах;
 - 7.2.1.2. Намын сум, хорооны салбарын даргыг сонгох;
 - 7.2.1.3. Сум, хорооны Танхимын гишүүдийг сонгох;
 - 7.2.1.4. Намын сум, хорооны салбарын албан ёсны байрны хаягийг батлах;
 - 7.2.2. Салбар байгуулсан хурлын тогтоолыг сонгогдсон анхан шатны салбарын дарга намын Бүртгэгчид хаяглан ирүүлнэ. Бүртгэгч нь салбар үүсгэн байгуулах хүсэлтийг нягталж, салбарыг албажуулах тухай тушаалын төслийг Намын даргад уламжилна.

7.2.3. Аймаг, дүүргийн хоёр ба түүнээс дээш тооны сум, хороонд Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын салбар байгуулагдсан бол тухайн аймаг, дүүргийн харьяа аль нэг сумын салбарын дарга, эсхүл ИОНН-ын төлөөлөгчдийн танхимын гишүүн аймаг, дүүргийн салбар байгуулах хурлыг товлон зарлаж, удирдаж болно. Аймаг, дүүргийн танхим байгуулах хурлаар дараах асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Үүнд:

7.2.3.1. Аймаг, дүүргийн Танхим байгуулах;

7.2.3.2. Аймаг, дүүргийн Танхимын даргыг сонгох;

7.2.3.3. Аймаг, дүүргийн Танхимын гишүүдийг батлах;

7.2.3.4. Аймаг, дүүргийн Танхимын албан ёсны байрны хаягийг батлах;

7.2.4. Танхим байгуулсан хурлын тогтоолыг сонгогдсон Танхимын дарга намын Бүртгэгчид хаяглан ирүүлнэ. Бүртгэгч нь Танхим үүсгэн байгуулах хүсэлтийг нягталж, танхимыг албажуулах тухай тушаалын төслийг Намын даргад уламжилна

7.2.5. Намын дарга нь сум, хорооны салбар, аймаг, дүүргийн танхимын үйл ажиллагааг албажуулахтай холбоотой дараах тушаалыг гаргана. Үүнд:

7.2.5.1. Шинээр байгуулагдсан салбар, танхимыг албажуулах,

7.2.5.2. Шинээр сонгогдсон салбар, танхимын даргад намын холбогдох тамга, албан бичгийн хуудас ашиглах зөвшөөрөл олгох,

7.2.5.3. Маргаан таслах комиссын шийдвэрийг үндэслэн салбар, танхим албажуулсантай холбоотой намын даргын тушаал, эсхүл тушаалын тодорхой хэсгийг хүчингүй болгох.

8 дугаар зүйл. Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага, сонирхлын бүлэг байгуулах

8.1. Намын үнэт зүйл, үзэл баримтлалын хүрээнд бодлогын стратеги, тактик боловсруулах, судалгаа хийх, намын гишүүдийг сургах, иргэдэд улс төрийн боловсрол түгээх эрхэм зорилго бүхий бодлогын судалгааны байгууллагыг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

8.1.1. Нам нь дэргэдээ бодлогын судалгааны байгууллагатай байна.

8.1.2. Намын бодлогын судалгааны байгууллага нь төрийн бус байгууллага, сангийн хэлбэртэй байж болох ба тогтмол үйл ажиллагаа явуулна.

8.1.3. Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд зохих хууль, журмын дагуу бүртгүүлэх бөгөөд Намын бүртгэгчид бүртгүүлнэ.

8.2. Намын гишүүд нийгэмд тулгамдсан асуудалд намын үнэт зүйлийн хүрээнд шийдэл хайхаар нэгдэж, тодорхой сэдэв, нийгмийн бүлгийн хүрээнд тогтмол бус үйл ажиллагаатай сонирхлын бүлэг, клуб байгуулан ажиллаж болно. Сонирхлын бүлэг, клубын гишүүд нь сайн дурын үндсэн дээр сонирхлын бүлэг, клубыг байгуулах, өөрчлөн байгуулах, нэгдэх, татан буулгах шийдвэрийг гаргах бөгөөд намын удирдах байгууллага, албан тушаалтан тус шийдвэрт оролцохгүй.

9 дүгээр зүйл. Намын байр, ажлын алба байгуулах, албан харилцааны хэрэгсэл

- 9.1. Намын байр, веб сайт, дотоод харилцаа холбооны апп зэрэг дэд бүтцийг бүрдүүлэх ажлыг намын дарга, салбар, танхимын байр зохион байгуулах ажлыг холбогдох салбар, танхимын дарга тус тус хариуцна.
- 9.2. Нам болон түүний салбар, танхимын нэр дээр үл хөдлөх хөрөнгө худалдан авахыг хориглоно.
- 9.3. Салбар, танхимын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах цахим болон харилцаа холбооны бусад арга хэрэгслийг гишүүн бүрд хүртээмжтэй ашиглах боломжтой нөхцөлд намын салбар, танхимын үйл ажиллагааг зөвхөн шаардлагатай тохиолдолд түр байранд ажиллах горимоор зохион байгуулж болно.
- 9.4. Намыг төлөөлж төрийн байгууллагатай харилцах албан харилцаанд намын албан хуудас, тамга ашиглах ба гишүүд, дэмжигчидтэй харилцах албан харилцаанд намын албан ёсны цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон бусад зөвшөөрөгдсөн харилцааны хэрэгслэл ашиглаж болно. Гэхдээ энэ нь үүсэж болох болзошгүй нөхцөл байдалд өөр арга хэрэгслэлээр харилцах харилцааг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.
- 9.5. Намын тамга, албан хуудас гээгдэж үрэгдэх буюу хуурамчаар үйлдэгдэх, цахим хуудас болон цахим харилцааны бусад хэрэгслэл халдлагад өртөх үед зөвхөн намын даргын гарын үсэг бүхий баримт бичгийг гадагш чиглэсэн албан харилцаанд хэрэглэнэ.
- 9.6. Гадаад улс, гадаадын байгууллагатай Нам харилцахад зөвхөн даргын гарын үсэгтэй албан бичиг, даргын албаны цахим шуудан ашиглана. Энэ эрхийг дарга өөрөө хэрэгжүүлэх боломжгүй байвал Намын гадаад харилцаа хариуцсан албан тушаалтанд бичгээр, түр эрх шилжүүлэн өгч болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

НАМЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 10 дугаар зүйл. Их Хурал, түүний чөлөөт цагт ажиллах Төлөөллийн төв байгууллага**
- 10.1. Намын эрх барих дээд байгууллага нь Намын Их хурал байна.
- 10.2. Намын ээлжит их хурал гурван жил тутамд тухайн жилийнхээ нэгдүгээр улиралд хуралдана. Намын ээлжит их хурлыг Төлөөлөгчдийн танхим 60-аас доошгүй хоногийн өмнө товлон зарлана. Намын их хурал зохион байгуулах ажлын хэсгийг намын их хурал болох өдрөөс дор хаяж 45 хоногийн өмнө Намын дарга томилно.
- 10.3. Намын их хурлын чөлөөт суудалд намын анхан шатны салбараас Төлөөлөгчдийн Танхимын тогтоосон ижил тэнцүү тоогоор төлөөлөгч сонгоно. Намын их хурлын чөлөөт бус суудалд намын дарга, маргаан таслах комиссын гишүүд, намын ерөнхий менежер, бүртгэгч томилолтоор орно.
- 10.4. Намын их хурлын нийт төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна.
- 10.5. Намын салбаргүй сум, хорооноос намын их хуралд оролцохоор гишүүн хүсэлт гаргавал намын их хурлыг зохион байгуулах ажлын хэсэг уг хүсэлтийг ажлын хэсгийн хурлаар

- хэлэлцэж шийдвэрлэнэ. Салбаргүй сум, хорооноос оролцох их хурлын төлөөлөгчдийн тоо нь салбарын хурлаас сонгогдсон төлөөлөгчдийн 10 хувиас хэтрэхгүй байна.
- 10.6. Намын дүрэм, үйл ажиллагааг Монгол улсын хуулийн заалтад тодорхой тогтоосон хугацаанд багтаан нийцүүлэх шаардлага үүссэн, намын даргын орон гарсан тохиолдолд ээлжит бус их хурал хуралдаж болно. Намын ээлжит их хурлын төлөөлөгч нь дараагийн ээлжит хурлын тов батлагдах хүртэлх хугацаанд болох намын ээлжит бус их хурлын төлөөлөгч байна. Намын даргын орон гарсан үед ээлжит бус их хурлыг товлон зарлах Төлөөлөгчдийн танхимын хурлыг намын ерөнхий менежер зарлаж, удирдана.
- 10.7. Дараах асуудлыг зөвхөн намын Их хурлаар хэлэлцэн, хуралд оролцсон төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэрлэж, батална:
- 10.7.1. Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, бүтэц зохион байгуулалтыг батлах;
- 10.7.2. Намын дүрмийн шинэчилсэн найруулга, намын дүрмийн гуравны нэгээс дээш заалтад оруулах нэмэлт өөрчлөлтийг батлах;
- 10.7.3. Намын Төлөөлөгчдийн танхим болон Маргаан Таслах Комиссын тайланг хэлэлцэх, тэдгээрийн бүрэлдэхүүнийг нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх;
- 10.7.4. Намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, намын нэрийг өөрчлөх.
- 10.7.5. Намын даргыг нууц санал хураалтаар сонгох, улируулах, чөлөөлөх, огцруулах;
- 10.7.6. Монгол улсын хуульд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;
- 10.8. Намын Их хурлын чөлөөт цагт Намыг Төлөөлөгчдийн танхим удирдана. Төлөөлөгчдийн танхимын гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.
- 10.9. Төлөөлөгчдийн Танхим нь намын төлөөллийн төв байгууллага мөн.
- 10.10. Төлөөлөгчдийн танхим нь нийтлэг суудалд нэр дэвшиж сонгогдсон 30 эрэгтэй, 30 эмэгтэй, жендер харгалзахгүй 3, аймаг, дүүргийн суудалд тухайн салбар бүрээс нэр дэвшиж сонгогдсон 2 эрэгтэй, 2 эмэгтэй, нийслэлийн суудалд нэр дэвшиж сонгогдсон 5 эмэгтэй, 5 эрэгтэй, нийгмийн бүлгийн төлөөллийн суудалд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл 2 эрэгтэй, 2 эмэгтэй (дохионы хэлний орчуулагчийг оруулахгүйгээр), чөлөөт бус суудалд томилогдсон Намын дарга, Бүртгэгч, Ерөнхий менежер нараас тус тус бүрдэнэ.
- 10.11. Намын Төлөөлөгчдийн Танхим нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлж, Төлөөлөгчдийн танхимын хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 10.11.1. Үнэт зүйлийн зөвлөлийн гишүүдийг нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх;
- 10.11.2. Намын Бүртгэгчийг нууц санал хураалтаар сонгох, улируулах, чөлөөлөх, огцруулах;
- 10.11.3. Ерөнхий Менежерийг нууц санал хураалтаар сонгох, улируулах, чөлөөлөх, огцруулах;
- 10.11.4. Дотоод сонгуулийн төв ажлын хэсгийг нууц санал хураалтаар сонгож байгуулах;
- 10.11.5. Намын дүрэм, мөрийн хөтөлбөрийн гуравны нэг хүртэлх заалтад бүрэлдэхүүнийхээ гуравны хоёрын саналаар нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 10.11.6. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын сонгууль, Засгийн Газрын томилгооны үйл явцад нам дангаараа эсхүл өөр намтай эвсэл байгуулж, эсхүл өөр нам эвслийг дэмжиж оролцох эсэх;

- 10.11.7. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын сонгууль, нөхөн сонгуульд намаас нэр дэвшигчийг нууц санал хураалтаар сонгож батлах;
- 10.11.8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр батлах;
- 10.11.9. Энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулах “Дүрэм хэрэгжүүлэх заавар”, болон хууль тогтоомж, энэхүү дүрмээр тусгайлан заасан журмыг батлах;
- 10.11.10. Жил бүрийн 12 дугаар сарын 31-нээс өмнө дараа жилийн төсвийг баталж, тухайн жилд төлөх гишүүний татварын хэмжээг тогтоох;
- 10.11.11. Намын ээлжит бус их хурлын товыг зарлах, ээлжит бус их хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулах;
- 10.11.12. Монгол улсын хууль, энэхүү дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.

11 дүгээр зүйл. Сум, Хорооны Бүх гишүүдийн хурал, сум, хорооны танхим, салбарын дарга

- 11.1. Сум, хорооны салбарын гишүүдийн хурал нь гишүүд намын анхан шатанд оролцоогоо илэрхийлэх, сонгох, сонгогдох эрхээ эдлэх гол талбар бөгөөд тухайн засаг захиргааны нэгж дэх намын үйл ажиллагааг удирдана.
- 11.2. Сум, хорооны бүх гишүүдийн хурал жил бүр хуралдаж дараах асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ.
 - 11.2.1. Намын орон нутгийн анхан шатны төлөөллийн байгууллага болох сум, хорооны танхимыг бүх гишүүдийн хурлаас 3-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр, гурван жилийн бүрэн эрхтэйгээр байгуулах, түүний бүрэлдэхүүнийг нууц санал хураалтаар сонгох, өөрчлөлт оруулах, чөлөөлөх;
 - 11.2.2. Сум, хорооны салбарын даргыг гурван жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх;
 - 11.2.3. Сум, хорооны салбарын байрыг батлах, өөрчлөх;
 - 11.2.4. Намын ээлжит их хурлын төлөөлөгчийг нууц санал хураалтаар сонгох;
 - 11.2.5. Аймаг, дүүргийн танхимын гишүүнийг нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх.
- 11.3. Сум, хорооны Танхим нь сум хорооны бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт намын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажиллана. Сум, Хорооны танхимыг сум, хорооны салбарын дарга тэргүүлнэ.
- 11.4. Сум, хорооны Танхим нь хагас жил тутамд хуралдаж, олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
 - 11.4.1. Сум, хорооны салбарын төсвийг батлах, өөрчлөлт оруулах;
 - 11.4.2. Намын ээлжит их хурлын төлөөлөгчид орон гарсан тохиолдолд намын ээлжит бус их хурлын төлөөлөгчийг нууц санал хураалтаар сонгох;
 - 11.4.3. Аймаг, дүүргийн Танхимд бүрэн эрхийн хугацаанаас өмнө орон гарсан тохиолдолд гишүүнийг нөхөн нууц санал хураалтаар сонгох;
 - 11.4.4. Сум, хорооны төрийн улс төрийн албанд намаас нэр дэвшүүлэх;

- 11.4.5. Сум түүний баг, нийслэлийн хорооны түвшинд явагдаж буй төрийн сонгуульд нам оролцох, бусад намтай эвсэх эсэхийг шийдвэрлэх, тус сонгуульд намын баримтлах мөрийн хөтөлбөрийг батлах;
 - 11.4.6. Сум хорооны салбарын санхүү, үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах
 - 11.4.7. Монгол улсын хууль, энэхүү дүрэм, түүний хүрээнд гарсан журамд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.
- 11.5. Сум, хорооны Бүх гишүүдийн хурал болон Танхимын гүйцэтгэх алба нь сум, хорооны ажлын алба байна. Ажлын албыг сум, хорооны салбарын дарга, эсхүл түүний томилсон менежер удирдаж болно. Ажлын албанд салбарын даргын томилсон санхүүч байх бөгөөд ажлын албаны данс Намын Санхүүчид бүртгэлтэй байна.
- 11.6. Сум, хорооны салбарын дарга нь дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
- 11.6.1. Салбарын бүх гишүүдийн хурал, салбарын танхимын хурлыг товлон зарлах, удирдах;
 - 11.6.2. Салбарын ажлын албыг байгуулах, ажлын албаны ажилтанг томилох, чөлөөлөх;
 - 11.6.3. Монгол улсын хууль, энэхүү дүрэм, түүний хүрээнд гарсан журамд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.
- 11.7. Сум, хорооны салбарын дарга намын гишүүдийн сонгох, сонгогдох эрхийг дараах байдлаар зөрчсөн нь түүнийг огцруулах үндэслэл болно. Үүнд:
- 11.7.1. Намын их хурлын төлөөлөгч, аймаг, дүүргийн танхимын гишүүн сонгох асуудлыг хэлэлцүүлэхээр Төлөөлөгчдийн Танхимаас ерөнхий товыг баталсан салбар, танхимын хурлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр батлагдсан хугацаанд товлон зарлаагүй, товлон зарласан хуралдаа оролцоогүй, удирдаж хийлгэсэн хурлын шийдвэрийг намын зохих ажлын хэсэгт хугацаанд нь илгээгээгүй.
 - 11.7.2. Сум, хорооны сонгуульд нам оролцох, намаас тус сонгуульд нэр дэвшүүлэхтэй холбоотой асуудлаар хуулиар тогтоосон хугацаанд холбогдох хурлыг товлон зарлаагүй, товлон зарласан хуралдаа оролцоогүй, удирдаж хийлгэсэн хурлын шийдвэр, хуулиар заасан бусад баримт бичиг, сонгуульд оролцсонтой холбоотой тайланг төрийн зохих байгууллагад хугацаанд нь илгээгээгүй.
- 11.8. Энэ дүрмийн 11.7-д заасан салбарын даргыг огцруулах үндэслэл гарсан тохиолдолд Салбарын бүх гишүүдийн хурлыг намын даргын томилсон хурал зохион байгуулагч товлон зарлаж, хурлыг удирдаж, салбарын даргыг огцруулах эсэх, шинээр салбарын дарга сонгох эсэх асуудлыг тус тус хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

12 дугаар зүйл. Аймаг, Дүүрэг, Нийслэлийн Танхим, танхимын дарга, ажлын алба

- 12.1. Аймаг, дүүрэг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй анхан шатны салбарын ажлын уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, гишүүдийн сонгох, сонгогдох эрхийг аймаг, дүүргийн түвшинд хангах, намын үйл ажиллагааг тухайн дэвсгэрт удирдах үүрэгтэйгээр Аймаг, Дүүрэг, Нийслэлийн Танхим ажиллана.
- 12.2. Аймаг, дүүргийн танхим нь дараах бүрэлдэхүүнтэй байна.
- 12.2.1. Аймаг, дүүргийн танхимыг анхан шатны хоёр салбар нэгдэж байгуулсан тохиолдолд тус салбарын танхимын гишүүд,
 - 12.2.2 Аймаг, дүүргийн танхимыг гурав ба түүнээс дээш тооны анхан шатны салбар нэгдэж байгуулсан, эсхүл ээлжит хурлын өмнө тус аймаг, дүүрэгт ийм тооны анхан шатны

салбартай болсон бол аймаг, дүүргийн танхимыг аймгийн төвөөс бусад сумын салбар тус бүрээс сонгогдсон 1 эмэгтэй, 1 эрэгтэй гишүүн; аймгийн төвийн сум, хотын салбараас сонгогдсон 2 эмэгтэй, 2 эрэгтэй гишүүн, дүүргийн хороо тус бүрээс сонгогдсон 1 эрэгтэй, 1 эмэгтэй гишүүн бүрдүүлнэ.

- 12.3. Аймаг, дүүргийн Танхимын шинээр сонгогдсон бүрэлдэхүүний анхны хурлыг аймаг, дүүргийн салбарын дарга, даргыг сонгоогүй, эсхүл хүндэтгэх шалтгаанаар намын ажлаас чөлөө хүссэн, нас барсан, гэмт хэрэг үйлдэж цагдан хоригдсон бол тус тус Намын даргын тушаалаар томилогдсон салбарын даргын үүрэг гүйцэтгэгч товлон зарлаж хуралдуулна.
- 12.4. Нийслэлийн Танхимыг дүүргийн салбарын дарга нар, нийслэлийн танхимын дарга бүрдүүлнэ. Нийслэлийн танхимын даргаар дүүргийн салбарын дарга давхар ажиллахыг хориглоно.
- 12.5. Нийслэлийн Танхимын анхны хурлыг Намын дарга товлон зарлана. Нийслэлийн танхимын анхны хуралдааныг дүүргийн салбарын дарга нарын хамгийн ахмад нь даргална.
- 12.6. Нийслэлийн Танхимын анхны хуралдаанаас дараах шийдвэрийг нууц санал хураалтаар гаргана. Үүнд:
 - 12.6.1. Намын нийслэлийн танхим байгуулах;
 - 12.6.2. Нийслэлийн танхимын даргыг сонгох;
 - 12.6.3. Нийслэлийн танхимын албан ёсны байрны хаягийг батлах.
- 12.7. Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхим нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 12.7.1. Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхимын даргыг гурван жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгох, улируулах, чөлөөлөх;
 - 12.7.2. Аймаг, дүүрэг, нийслэлийн иргэдийн төлөөллийн байгууллагад намаас нэр дэвшигчийг нууц санал хураалтаар тодруулах;
 - 12.7.3. Аймаг, дүүрэг, нийслэлийн түвшинд явагдаж буй төрийн сонгуульд оролцох, сонгуульд өөр намтай эсвэл болж оролцох эсэх, сонгуульд намын баримтлах мөрийн хөтөлбөрийг батлах;
 - 12.7.4. Аймаг, дүүрэг, нийслэлийн салбарын төсвийг батлах, өөрчлөлт оруулах;
 - 12.7.5. Аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын санхүү, үйл ажиллагааны нэгтгэсэн тайланг хэлэлцэж, батлах
 - 12.7.6. Монгол Улсын хууль тогтоомж, намын дүрэм, журмаар тусгайлан заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.
- 12.8. Аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын дарга холбогдох танхимын хурлыг товлон зарлах, удирдах бүрэн эрх, үүрэгтэй байх ба намын санхүү, эд хөрөнгө захиран зарцуулах эрхгүй байна.
- 12.9. Аймаг, дүүрэг, нийслэлийн түвшний сонгуульд нам оролцох, намаас тус сонгуульд нэр дэвшүүлэхтэй холбоотой асуудлыг хэлэцүүлэх хурлыг хуулийн хугацаанд товлон зарлаагүй, товлон зарласан хуралдаа оролцоогүй, удирдаж хийлгэсэн хурлын шийдвэр, хууль тогтоомжид заасан баримт бичиг, сонгуульд оролцсонтой холбогдуулан гаргах санхүүгийн тайланг төрийн зохих байгууллагад хуулийн хугацаанд илгээгээгүй нь аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын даргыг огцруулах үндэслэл болно.
- 12.10. Энэ дүрмийн 12.9-т заасан огцруулах үндэслэл гарсан тохиолдолд аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын хурлыг намын даргын томилсон хурал зохион байгуулагч товлон

зарлаж, хурлыг удирдаж, танхимын даргыг огцруулах эсэх, шинээр танхимын дарга сонгох эсэх асуудлыг тус тус хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. .

- 12.11. Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхимын гүйцэтгэх алба нь аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын ажлын алба байна. Ажлын албыг аймаг, дүүрэг, нийслэлийн Танхимын даргын томилсон менежер удирдах бөгөөд ажлын албаны санхүү, эд хөрөнгийг захиран зарцуулна. Ажлын албанд менежерийн томилсон санхүүч байх бөгөөд ажлын албаны данс ИОНН-ын Бүртгэгчид бүртгэлтэй байна. Аймаг, дүүргийн ажлын албаны менежерийн томилсон санхүүч нь сум, хорооны салбарын санхүү, үйл ажиллагааны тайланг нэгтгэж намын Санхүүчид илгээх үүрэгтэй.

13 дугаар зүйл. Үнэт Зүйлийн Зөвлөл

- 13.1. Үнэт зүйлийн зөвлөл нь намын өдөр тутмын улс төрийн үйл ажиллагааг эрхлэн явуулах гүйцэтгэх төв байгууллага мөн.
- 13.2. Үнэт зүйлийн зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.
- 13.3. Үнэт зүйлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд нийгмийн залуу ба ахмад, эрэгтэй ба эмэгтэй, тусгай хэрэгцээт бүлгийн гишүүдийн төлөөллийг жигд оролцуулах үүднээс дараах суудалд сонгоно. Үүнд:
- 13.3.1. 40 ба түүнээс дээш насны 5 эмэгтэй, 5 эрэгтэй;
 - 13.3.2. 39 ба түүнээс доош насны 5 эмэгтэй, 5 эрэгтэй;
 - 13.3.3. Тусгай хэрэгцээт гишүүдийн төлөөлөл 1 эмэгтэй, 1 эрэгтэй;
 - 13.3.4. Намын дарга.
- 13.4. Үнэт зүйлийн зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 13.4.1. Цаг үеийн улс төрийн нөхцөл байдалд дүгнэлт өгөх, мэдэгдэл гаргах;
 - 13.4.2. Намын дарга, орон нутгийн намын байгууллага, намын ажлын албанд улс төрийн үүрэг, чиглэл өгөх;
 - 13.4.3. Намын Их Хурал, Төлөөлөгчдийн Танхимын эрх хэмжээнд хамаарахаас бусад улс төрийн албан тушаалд намаас нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэх;
 - 13.4.4. УИХ, нийслэл, аймаг, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал дахь намын бүлгийн баримтлах улс төрийн байр суурьт чиглэл өгөх;
 - 13.4.5. Энэ дүрмийн 4.7.1 - 4.7.4 дахь заалтын дагуу намын гишүүн, албан тушаалтан, бүтцийн байгууллагаас ирсэн гомдлыг хүлээн авч, хэлэлцэх, шийдвэр гаргах, шийдвэрийг Бүртгэгчид илгээх;
 - 13.4.6. Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагыг батлах, үйл ажиллагааны тайланг сонсох;
- 13.5. Үнэт зүйлийн зөвлөлийн ээлжит хурлыг Намын дарга, ээлжит бус хурлыг Намын дарга, эсхүл ҮЗЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь гарын үсэг зурснаар зарлан хуралдуулна.
- 13.6. Үнэт зүйлийн зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд нэг удаа зарлаж, 12-оос доошгүй гишүүн ирснээр хуралдаж, ирсэн гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана.

14 дугаар зүйл. Намын Дарга

- 14.1 Намын дарга нь намыг гадаад, дотоодод төлөөлнө.
- 14.2 Намын даргыг гурван жилийн хугацаагаар Намын Их Хурлаас нууц санал хураалтаар сонгох ба намын даргыг 3 хүртэл удаа улируулан сонгож болно. Намын даргын бүрэн эрх дараагийн даргыг намын Их Хурлаар сонгосон тогтоол батлагдсанаар дуусгавар болно.
- 14.3 Намын дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
 - 14.3.1 Намын Их хурал товлон зарлах, хурлын дарга, тэргүүлэгчдийг санал оруулах;
 - 14.3.2 Төлөөлөгчийн танхим, Үнэт зүйлийн хорооны хурлыг товлон зарлах, удирдах; хурал даргалах эрхийг шилжүүлэх шаардлагатай гэж үзвэл хурлын дарга тэргүүлэгчийг санал оруулах;
 - 14.3.3 Намын нийслэлийн Танхимын анхдугаар хурлыг товлон зарлах;
 - 14.3.4 Намын Ерөнхий менежерийг Төлөөлөгчдийн Танхимаар томилуулахаар санал оруулах;
 - 14.3.5 Намын Үнэт зүйлийн зөвлөлийн бүрэлдэхүүний 51 хүртэлх хувийг Төлөөлөгчдийн Танхимаар сонгуулахаар санал оруулах;
 - 14.3.6 Намын гишүүдийн ойлголцол, эв нэгдлийг хангах, намын хөрөнгө босгох үйл ажиллагаанд манлайлан оролцох;
 - 14.3.7 Намын дотоод аудит, эрсдэлийн удирдлагын багийн хурлыг зарлах, сонсголыг удирдах;
 - 14.3.8 Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;
- 14.4 Намын даргад дараах үйлдлийг хориглоно:
 - 14.4.1 Бүртгэгчид хэн нэгнийг оноож нэр дэвшүүлэх, Төлөөлөгчдийн Танхимын сонгосон Бүртгэгчтэй хамтран ажиллахаас татгалзах, Бүртгэгчийн үйл ажиллагаанд хууль бус шахалт үзүүлэх;
 - 14.4.2 Намын санхүү, төсвийг захиран зарцуулах акт баримтад гарын үсэг зурах;
 - 14.4.3 Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нам оролцох, намаас тус сонгуульд нэр дэвшүүлэхтэй холбоотой асуудлаар хуулиар тогтоосон хугацаанд холбогдох хурлыг товлон зарлахгүй, товлон зарласан хуралдаа оролцохгүй байх.
- 14.5 Энэ дүрмийн 14.4 дэх зүйлд заасан үйлдлийг Намын дарга гаргасан нь түүнийг огцруулах үндэслэл болно.
- 14.6 Намын дарга дараах нөхцөлийн улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бол түүнийг дараагийн намын дарга сонгогдон Улсын дээд шүүхэд бүртгэгдэх хүртэлх хугацаанд Намын ерөнхий менежер түр орлоно. Үүнд:
 - 14.6.1 Нас барсан;
 - 14.6.2 Гэмт хэрэг үйлдэж ял авсны улмаас иргэний эрхээ хязгаарлуулсан;
 - 14.6.3 Намын даргаас огцорсон;

- 14.6.4 Хүнд өвчний улмаас намын үйл ажиллагаанд нэг жилээс доошгүй хугацаанд оролцох боломжгүй болсныг өөрөө буюу гэр бүлийн гишүүний зүгээс Намын Ерөнхий менежерт хаяглан бичгээр илэрхийлсэн;

15 дугаар зүйл. Намын ерөнхий менежер, ажлын алба

- 15.1 Намын ерөнхий менежерийг намын даргын санал болгосноор Төлөөлөгчдийн танхимаас 3 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгоно. Ерөнхий менежерийг 3 хүртэл удаа улируулан ажиллуулж болно.
- 15.2 Намын ерөнхий менежер нь намын ажлын албыг зохион байгуулж, удирдах ба намын хөрөнгө, санхүүг захиран зарцуулна.
- 15.3 Ерөнхий менежер нь намын ажлын албаны ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан, ажлын байрны тодорхойлолтыг гаргана. Намын гишүүн намын ажлын албанд сайн дураар ажиллаж, өөрийн ажилласан цагийг мөнгөн бус хандивт тооцуулж болно.
- 15.4 Намын ажлын албаны бүтцэд дараах болон шаардлагатай бусад ажилтан, газар, хэлтэс багтаж болох ба ажлын албаны бүтэц, орон тоог Намын дарга батална.
- 15.4.1 Бүртгэгч;
- 15.4.2 Намын нарийн бичгийн дарга;
- 15.4.3 Санхүүч / Нягтлан бодогч;
- 15.4.4 Эрсдлийн удирдлагын газрын дарга
- 15.4.5 Мэдээллийн технологийн ажилтан;
- 15.4.6 Мэдээлэл сурталчилгааны ажилтан.
- 15.5 Намын ерөнхий менежер нь салбар, танхимын ажлын албыг нэгдсэн удирдлагаар хангана.
- 15.6 Намын ерөнхий менежер нь Маргаан Таслах комисс, Дотоод сонгуулийн ажлын хэсэг, Тандалт үнэлгээний ажлын хэсгийг болон бусад ажлын хэсгийг ажиллах нөхцөлөөр хангана.
- 15.7. Намын Ажлын алба нь намын нэгдсэн цахим системийг ажиллуулан, уг нэгдсэн цахим системийн тасралтгүй, аюулгүй, найдвартай ажиллагааг хангана.
- 15.8 Мэдээллийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж түүнд шаардлагатай удирдлагаар хангаж ажиллана.
- 15.9 Намын ажлын албаны дараа жилийн төсвийг Төлөөлөгчдийн Танхим жил бүрийн 12-р сарын 20-ны дотор батална.
- 15.10 Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох талаар намын Төлөөлөгчдийн танхимаас гарсан шийдвэр, хуулиар заасан бусад баримт бичиг, сонгуульд оролцсонтой холбоотой тайланг төрийн зохих байгууллагад хугацаанд нь илгээгээгүй нь Ерөнхий менежерийг огцруулах үндэслэл болно.

16 дугаар зүйл. Бүртгэгч

- 16.1 Бүртгэгч нь намын дотоод ил тод байдал, шударга, тэгш байдал, дотоод ардчиллыг хангах чиг үүрэг бүхий сонгуульт, орон тооны, гүйцэтгэх албан тушаал мөн.
- 16.2 Бүртгэгч нь үүрэгт ажлаа гүйцэтгэж байх хугацаандаа намын дотоод сонгууль болон төрийн сонгуульд оролцохгүй.
- 16.3 Бүртгэгч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
 - 16.3.1 Намд элсэхээр бичгээр болон цахимаар өргөдөл гаргасан, апп-аар хүсэлт ирүүлсэн Монгол улсын иргэнийг өөр улс төрийн намд харьяалалтай эсэхийг лавлах, хөндлөнгийн гэрчээс тодруулга авах, батлан даагчаас баталгаа авах замаар нягталж намын гишүүнээр бүртгэн авах;
 - 16.3.2 Намын гишүүдийн орон нутгийн болон статусын шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, намын татвар, дотоод сонгууль зохион байгуулагдаж буй саруудад намын гишүүний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг нэг календарийн жилд гурван сараас илүүгүй хугацаагаар зогсоох
 - 16.3.3 Намын аливаа дотоод сонгуулийн өмнө саналын эрхтэй гишүүдийн тоо, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг хассан жагсаалтыг гаргаж дотоод сонгууль зохион байгуулах ажлын хэсэгт нэр дэвшигчийн сурталчилгаа эхлэхээс өмнө хүлээлгэн өгөх;
 - 16.3.4 Намын татвар, хуримтлал, хандив хүлээн авах данс, тус данснаас гүйлгээ хийх эрх бүхий этгээд, намын албан бичиг, тогтоол шийдвэрт гарын үсэг зурах эрх бүхий этгээд, тамга, тэмдгийн хэв, намын албан ёсны вэбсайт, пэйж, цахим хаягууд, тэдгээрт нэвтрэх эрх эзэмшигч нарын бүртгэлийг тус тус хийж, өөрчлөлтийг шинэчилж байх;
 - 16.3.5 Намын дотоод сонгуулиар намын төлөөллийн, гүйцэтгэх, хяналтын байгууллагад болон түр ажлын хэсэгт сонгогдсон, томилогдсон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа эхэлсэн, дууссан огноог бүртгэх;
 - 16.3.6 Бүртгэгч нь мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлан шалгахын тулд намын аль ч шатны байгууллага, албан тушаалтнаас тодруулга авах, намын гишүүдтэй ярилцлага хийх, намын цахим дата баазад нэвтрэх эрхтэй байна.
 - 16.3.7 Бүртгэгч нь давхардсан, намаас гарахаа илэрхийлсэн, намаас хасах шийдвэр гарсан, бүрэн эрхийн хугацаа дууссан шалтгаанаар аливаа мэдээллийг жагсаалтаас хасахын өмнө “Бүртгэлээс хасах акт”, алдаатай, ташаа орсон мэдээллийг залруулах, статус өөрчлөгдсөн шалтгаанаар бүртгэлд засвар хийхийн өмнө “Бүртгэлд өөрчлөлт оруулах акт” тус тус үйлдэж намын нарийн бичгийн даргад хүлээлгэн өгч намын архивт хадгалуулна.
 - 16.3.8 Бүртгэгч нь намын гишүүний бүртгэлтэй холбоотой хууль, тогтоомжид заасан мэдээ, мэдээлэл гаргахад оролцоно.
 - 16.3.9 Бүртгэгч нь эрх, үүргээ хэрэгжүүлэхийн тулд намын ажлын албанаас цалин, ажлын өрөө, тавилга, тоног төхөөрөмж, бичиг хэргийн болон харилцаа холбооны урсгал зардал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах хэрэгсэл, туслах ажилтан гаргуулан авах эрхтэй.
- 16.4 Бүртгэгчийг Төлөөлөгчдийн Танхимаас 5 жилийн хугацаатай 1 хүнийг нууц санал хураалтаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.

- 16.5 Бүртгэгч нь намын гишүүдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, намын дотоод ардчилалыг бэхжүүлэхэд шаардлагатай хөгжүүлэлтийг намын нэгдсэн мэдээллийн систем, апп, вебсайтад хийхэд нь мэдээллийн технологийн ажилтантай хамтран ажиллана.

17 дугаар зүйл. Намын дотоод сонгуулийн ажлын хэсэг

- 17.1 Төрийн сонгуульд оролцох Намаас нэр дэвшигчдийг тодруулах болон намын сонгуульд албан тушаалд нэр дэвшигчдийг сонгох дотоод сонгуулийг Намын дотоод сонгуулийн ажлын хэсэг удирдан зохион байгуулна. Намын дотоод сонгуулийн ажлын хэсэг нь байнгын бус, орон тооны бус гүйцэтгэх байгууллага мөн.
- 17.2 Намын бүх ээлжит дотоод сонгууль тухайн сонгуульд жилийн 03 дугаар сарын 01-ээс 31-ний хооронд багтан зохион байгуулагдана. Үүнд төрийн сонгуульд намаас нэр дэвшигчийг тодруулах хуулиар заасан хугацаа бүхий дотоод сонгууль хамаарахгүй.
- 17.3 Намын дотоод сонгуулийг зохион байгуулах эрх бүхий дотоод сонгуулийн ажлын хэсгийг Төлөөлөгчдийн Танхим байгуулна.
- 17.4 Дотоод сонгуулийг дараах байдлаар хугацаа дууссан, орон гарсан суудалд зарлана. Үүнд:
- 17.4.1. Бүрэн эрхийн хугацаа нь дууссан;
 - 17.4.2. Сонгуульд албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ намын дарга эсхүл бүртгэгчид бичгээр ирүүлсэн;
 - 17.4.3. Намын дүрмэнд заасны дагуу албан тушаалаас огцруулсан;
 - 17.4.4. Гишүүн шүүхээр гэм буруутай нь тогтоогдож эрүүгийн ял шийтгэл хүлээсэн;
 - 17.4.5. Гишүүн намаас гарсан;
 - 17.4.6. Гишүүн нас барсан.
- 17.5 Дотоод сонгуулийн ажлын хэсэг нэг жилийн хугацаатай томилогдох ба дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 17.5.1. Эрх бүхий байгууллагаас товлон зарласан дотоод сонгуульд нэр дэвшигчдийг бүртгэх сул орон тооны жагсаалт гаргаж уг орон тоонд дотоод сонгуульд нэр дэвшилтийг зарлах, нэр дэвшигчдийг бүртгэх, нэр дэвшилтийг хаах;
 - 17.5.2. Нэр дэвших өргөдлийн маягт батлах, зарлах;
 - 17.5.3. Анхан шатнаас бусад дотоод сонгуульд хоёр ба түүнээс дээш нэр дэвшигч бүртгэгдсэн бол тандалт үнэлгээний ажлын хэсэг томилуулах хүсэлтийг Намын даргад хүргүүлэх;
 - 17.5.4. Бүх шатны хуралд дотоод сонгуулийн нэр дэвшилтийг танилцуулах, нэр дэвшилт хаасны дараа үлдсэн сул орон тоонд хурал дээр нэр дэвших ажиллагааг зарлах, бүртгэх.
 - 17.5.5. Намын гишүүн саналаа нууцаар, чөлөөтэй гаргах, нэг хүн нэг санал хураалтад зөвхөн нэг удаа санал өгөх нөхцлийг хангах.
 - 17.5.6. Дотоод сонгуулийн дүнг мэдээлэх.

- 17.6 Дотоод сонгууль шударга бус болсон нь Маргаан таслах комиссын дүгнэлтээр тогтоогдож дахин сонгууль явуулах шийдвэр гарсан бол амжилтгүй сонгууль зохион байгуулахад оролцсон ажлын хэсгийн гишүүнийг хугацаанаас өмнө чөлөөлөх ба дахин сонгуулийг зохион байгуулах ажлын хэсэгт оруулахгүй.
- 17.7 Дотоод сонгуулийн ажлын хэсэгт томилогдон ажиллах хугацаанд нь гарсан зардлын баримт, гарах зардлын нэхэмжлэлд үндэслэн ажлын байр, урсгал зардал, гишүүдэд ажлын урамшуулал олгож болно. Энэхүү зардлыг нягталж, гаргах үүргийг намын ажлын алба хариуцна.
- 18 дугаар зүйл. Сонгуульд нэр дэвшүүлэх боловсон хүчнийг шилж сонгох, хүйсийн тэгш байдлыг хангах**
- 18.1 Намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх боловсон хүчнийг шилж сонгох үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулах бөгөөд тус журам нь энэхүү зүйлийн хүрээнд дараах гурван үе шатыг хамран зохицуулалт хийнэ.
- 18.1.1 Намын гишүүн өөрийгөө илэрхийлэх үе шат
- 18.1.2 Тандалт, үнэлгээний үе шат
- 18.1.3 Хуулиар эрх олгогдсон намын байгууллага шийдвэр гаргах үе шат
- 18.2 Намын гишүүн өөрийгөө илэрхийлэх үе шатанд дараах үйл ажиллагаа багтана:
- 18.2.1 Улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүний болзлыг ханган Бүртгэгчид бүртгүүлэх;
- 18.2.2 Төрийн ээлжит сонгуулийн хооронд хамгийн багадаа 1 удаа хандивлагч гишүүнээр бүртгэгдсэн байх;
- 18.2.3 Намын мөрийн хөтөлбөрт нийцсэн идэвхтэй үйл ажиллагааг зохион байгуулах, манлайлах, намын гишүүд дунд болон нийгэмд танигдах;
- 18.3 Тандалт, үнэлгээний үе шатанд дараах үйл ажиллагаа явуулна::
- 18.3.1 Намын гишүүн тандалт үнэлгээнд зориулсан хувийн тайлан гаргаж Тандалт үнэлгээний ажлын хэсэгт тогтоосон хугацаанд илгээнэ.
- 18.3.2 Тандалт үнэлгээний ажлын хэсэг гишүүдийн хувийн тайлан, хөндлөнгийн мэдээллийг үндэслэн тоон үзүүлэлтээр гишүүдийг эрэмбэлнэ.
- 18.3.3 Тандалт үнэлгээний ажлын хэсэг өрсөлдөгч гишүүдийн талаар холбогдох салбар танхимын гишүүдээс, санал тэнцсэн тохиолдолд хандивлагч гишүүдээс тус тус санал асуулга авч болно.
- 18.4 Хуулиар эрх олгогдсон намын байгууллага шийдвэр гаргах үе шатанд тухайн сонгуулийн үйл ажиллагааг зохицуулсан Монгол улсын хууль, намын Төлөөлөгчдийн танхимаас баталсан төрийн сонгуульд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохицуулах тусгай журмыг мөрдөж ажиллана.
- 18.5 Энэхүү дүрмийн 18.2-т заасны дагуу өөрийгөө илэрхийлсэн гишүүдэд намын гишүүдтэй холбогдох хаяг, мэдээллийг тэгш хүргэх үүргийг Намын ажлын алба хүлээх ба хууль эрх зүй, сонгуулийн кампанит ажил зохион байгуулах арга зүйн сургалтыг намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага эрхлэн явуулна. .

- 18.6 Намын эрх бүхий байгууллага төрийн сонгуулийн тухай хуульд заасан хугацаанд багтаж энэ дүрмийн 18.2-т заасны дагуу бүртгэгдсэн гишүүдийн дотроос 18.3-т заасан тандалт, үнэлгээний дүнд үндэслэн нэр дэвшүүлнэ.
- 18.7 Намаас төрийн сонгуульд нэр дэвшигчдийн дотор эрэгтэй, эмэгтэй аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас багагүй байна.

19 дугаар зүйл. Маргаан Таслах Комисс

- 19.1 Маргаан таслах комисс нь намын хяналтын төв байгууллага мөн. Маргаан таслах комиссын гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.
- 19.2 Маргаан таслах комисс 9 хүний бүрэлдэхүүнтэй байх ба шинээр сонгогдсон бүрэлдэхүүний анхны хурлыг хамгийн ахмад гишүүн удирдан явуулж, гишүүдийн олонхын саналаар тус комиссын даргыг нууц санал хураалтаар сонгоно.
- 19.3 Маргаан таслах комисс цахим болон боломжит хэлбэрээр хуралдана. Маргаан үүсгэсэн нөхцөл байдлыг баримтжуулах үүргийг маргаан үүсгэгч талууд хариуцах бөгөөд маргаан таслах комисс нотлох баримт бүрдүүлэх үйл ажиллагаанд оролцохгүй.
- 19.4 Маргаан таслах комисс хуралдаж олонхийн саналаар шийдвэр гаргана. Маргаан таслах комиссын хуралд комиссын гишүүдийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно. Маргаан таслах комиссын ажиллах журмыг Төлөөлөгчдийн танхим батална.
- 19.5 Маргаан таслах комисс нь Монгол Улсын улс төрийн намын тухай хууль, энэхүү дүрмийн хүрээнд ажиллаж маргааныг олонхын саналаар шийдвэрлэнэ. Ингэхдээ хүний суурь эрх, эрх чөлөөнд халдсан асуудал авч хэлэлцэхгүй бөгөөд суурь эрх, эрх чөлөөнд халдсан санал хураалт явуулахгүй.
- 19.6 Маргаан таслах комиссын хурал дараах бүрэн эрхтэй:
- 19.6.1 Маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэх;
- 19.6.2 Дүгнэлт, зөвлөмж гаргах;
- 19.7 Маргаан таслах комиссын гишүүдийн ажлын байр, ажлын хөлс, бусад урсгал зардлыг Намын ажлын алба хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

НАМЫН САНХҮҮЖИЛТ

20 дугаар зүйл. Намын хөрөнгө, орлого

- 20.1 Намын эд хөрөнгөд үл хөдлөх хөрөнгөөс бусад дараах төрлийн эд хөрөнгө байна.

- 20.1.1. Гишүүний татвар;
- 20.1.2. Гишүүн, талархан дэмжигч иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив;
- 20.1.3. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг;
- 20.1.4. Намын бэлгэдэл, оюуны өмч бүхий бэлэг дурсгалын зүйлс, намын өмчлөлд байгаа эд юмс, намын оюуны өмч шингэсэн бүтээгдэхүүнийг борлуулсан орлогоос ногдох хувь;
- 20.1.5. Намын хэвлэл, мэдээлэл, сурталчилгаа, сургалтын орлого;
- 20.1.6. Өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олсон орлого;
- 20.1.7. Намын мөнгөн хөрөнгийг банкинд хадгалуулсны хүү.

20.2 Нам компани болон бизнесийн бусад байгууллагад хувь эзэмшихгүй

21 дүгээр зүйл. Намын орлогын зарцуулалт

- 21.1 Намын орлогыг зөвхөн намын мөрийн хөтөлбөр, дүрмээр болон Улс төрийн намын тухай хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулахад зарцуулна.
- 21.2 Намын орлогыг энэ дүрмийн 21.1-д зааснаас өөр зүйлд зарцуулах, гишүүдэд ногдол ашиг болгон хуваарилахыг хориглоно.
- 21.3 Намын үйл ажиллагаанд орлогыг зарцуулахдаа зорилтот үр дүнд хүрэх хамгийн хэмнэлттэй хувилбарыг сонгох зарчмыг баримтална.

22 дугаар зүйл. Гишүүний татвар, намд өгөх хандив

- 22.1 Намын гишүүний жилийн татварыг Төлөөлөгчийн Танхимаас тогтоосон хэмжээгээр, улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүний жилийн татварыг өмнөх жилийн нийт хуримтлалын 1 хувиас хэтрэхгүй хэмжээгээр гишүүн өөрөө тогтоож намын дансанд дараах хуваарийн дагуу төлнө.
 - 22.1.1 Дотоод сонгуулийн өмнөх татвар төлөлт: 2 дугаар сарын 1-ний дотор;
 - 22.1.2 Дотоод сонгуулийн дараах татвар төлөлт: 4 сарын 1-нээс 12 сарын 10-ны дотор;
 - 22.1.3 Хуримтлал бүрдүүлэгч гишүүний татвар төлөлт: сонгуульд нэр дэвшихээ илэрхийлсэн гишүүн тандалт үнэлгээний хувийн тайлангаа энэ дүрмийн 18.3.1 дэх заалтын дагуу илгээхээс өмнө.

22.2. Гишүүн, дэмжигчид үзэл бодол, итгэл үнэмшлээрээ намыг дэмжин хандив өргөж болно. Мөнгөн хандивыг намын дансаар хүлээн авна. Мөнгөн бус хандивыг хүлээн авсан намын ажлын албаны ажилтан нь бичгээр гэрээ, актын аль нэгийг үйлдэж намын санхүүд хүлээлгэн өгнө.

22.3 Намд зориулж иргэн, аж ахуйн нэгжээс өгөх хандивын хэмжээ нь Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль тогтоомжид заасны дагуу байна. Намд хандив өгсний төлөө албан тушаал, хувийн эрх ашиг хөөцөлдөх, шахалт үзүүлэхийг хориглоно.

22.4 Нам авсан хандивынхаа талаар нийтэд мэдээлж байна.

22.5 Гишүүний татвар болон хандивыг тооцооны нэг дансанд байршуулна. Энэхүү дансыг намын төв болон салбарын Ажлын Алба намын Бүртгэгчид бүртгүүлж, жил бүр дансанд хөндлөнгийн аудит хийлгэнэ.

22.6 Сонгуулийн үйл ажиллагаанд зориулж намд хандив авах, зарцуулах, тайлан гаргах үйл ажиллагааг сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулна.

22.7 Дараах этгээдээс хандив авахыг хориглоно:

22.7.1 арван найман насанд хүрээгүй Монгол Улсын иргэн;

22.7.2 төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага, лиценз эзэмшдэг, төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэдэг аж ахуйн нэгж;

22.7.3 шашны байгууллага;

22.7.4 олон улсын байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн;

22.7.5 байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд;

22.7.6 тодорхой нэр хаяггүй этгээд;

22.7.7 дампуурсан болон банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй хуулийн этгээд;

22.7.8 Хуулиар хориглосон бусад этгээд.

22.8 Олон улсын байгууллага болон улс төрийн үйл ажиллагаа явуулдаг гадаадын байгууллага, сантай нам болон намын салбар байгууллага, намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага хамтран төсөл хэрэгжүүлэх санхүүжилт энэ дүрмийн 22.7.4-т хамаарахгүй.

23 **дугаар зүйл. Намын үйл ажиллагааг төлбөрийн чадварт нийцүүлэх**

23.1 Намын бүх шатны хурлыг дан цахимаар, бүх гишүүд биечлэн оролцох, эсхүл цахим ба биечлэн оролцооны холимог хэлбэрийн аль бага өртөгтэй, нийтийн эрүүл мэндэд аюулгүй, оролцооны хувь өндөртэй байдлаар нь зохион байгуулна.

23.2 Намын гишүүний нэг жилийн татварыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хүртэл хувиар тогтооно.

23.3 Хөдөлмөрийн чадвараа 30 хувиас дээш хэмжээгээр алдсан бол гишүүний татварыг энэ Намын дүрмийн 23.2-т заасан дүнгийн 50 хувиар тооцно. Хөдөлмөрийн чадвар сэргээн тогтоосон бол энэ тухай мэдэгдэж нийтлэг дүнгээр татвараа төлнө.

23.4 Намын сургалт, арга хэмжээ олонх гишүүдийн төлбөрийн чадварт нийцэхүйц төлбөртэй байж болно. Гишүүдийн олонхын төлбөрийн чадвараас давсан өндөр үнэтэй сургалт, арга хэмжээг намын нэрээр зохион байгуулахыг хориглоно.

23.5 Намын өдөр тутмын үйл ажиллагаа, бүртгэл, нийтийн зар, дотоод сонгууль, тандалт судалгаанд цахим технологи голлон ашиглана.

24 **дүгээр зүйл. Эрсдэлийн удирдлага, дотоод аудит, санхүүгийн тайлан**

24.1 Намын үйл ажиллагаа, санхүүд Намын дарга, Ерөнхий менежер, Ажлын албан дахь Эрсдэлийн удирдлагын газар тогтмол хяналт тавина.

- 24.2 Үйл ажиллагаа, санхүүгийн тогтмол хяналтыг хэрэгжүүлэх механизм нь Эрсдэлийн Удирдлагын газрын хурал мөн. Энэхүү хурлын бэлтгэл ажлыг Эрсдлийн удирдлагын газрын дарга зохион байгуулна.
- 24.3 Эрсдлийн удирдлагын газрын хурлын товыг Эрсдлийн удирдлагын газрын дарга намын даргатай зөвшилцөн зарлах ба Эрсдлийн удирдлагын газрын хуралд Намын дарга, Ерөнхий менежер, хэлэлцэх асуудалд хамаарал бүхий бусад гишүүн, ажилтан оролцоно.
- 24.4 Энэхүү дүрмийн 24.2-т заасан хуралд хөндлөнгийн аудитор, хэлэлцэж буй асуудлаар мэргэшсэн шинжээч нарыг оролцуулж болно.
- 24.5 Намын санхүүгийн тайланг Улс төрийн намын тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу гаргана. Ажлын Алба салбарын санхүүгийн тайлан гаргасны дараа нэгдсэн тайлан гаргана.
- 24.6 Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр хөндлөнгийн санхүүгийн аудит хийлгэж, аудитаас гарсан дүгнэлтийг нийтэд мэдээлнэ. Үүнд Монгол Улсын аудитын тухай хуулийг баримтална.
- 24.7 Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн болон нөхөн сонгуулийн зардлын тайланг гаргахтай холбогдох харилцааг сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулна.
- 24.8 Улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүний хуримтлалын дансыг дотоод сонгууль болон төрийн сонгуулиас бусад хугацаанд битүүмжтэй байлгаж, зарлага гаргахгүй ба хуульд заасан хэмжээгээр, хуулиар хориглоогүй этгээдээс хандив авахад Эрсдлийн удирдлагын газар хяналт тавьж ажиллана.

ТАВДУГААР БҮЛЭГ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ, ШИЙДВЭР ГАРГАЛТ

25 дугаар зүйл. Нийтийн зар, хурлын ирц, санал хураалтын горим, хурал удирдах

- 25.1 Энэ дүрэмд заасан намын хурал, дотоод сонгууль, намын аливаа шийдвэрийн төслийн хэлэлцүүлэг, намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх сонгон шалгаруулалттай холбоотой үйл ажиллагааны аливаа зарыг нийтийн зар гэнэ. Намын доторх сонирхлын бүлгүүдийн уулзалт цугларалт, тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээ зэрэгт хамаарах зар нь нийтийн зард тооцогдохгүй.
- 25.2 Нийтийн зарыг тухайн үйл ажиллагаанд таслах эрхтэй бүх гишүүнд ижил арга хэрэгслээр, ижил хугацаанд, Дотоод сонгуульд нэр дэвшигч бүрт хамааралтай хурал, бүртгэлийн зарыг ижил арга хэрэгслээр, ижил хугацаанд тус тус түгээнэ.
- 25.3 Нийтийн зарыг бүх гишүүдэд түгээх үндсэн арга хэрэгсэл нь намын веб сайт, намын апп, намын албан ёсны сошл пейж хаяг байна. Эдгээр арга хэрэгслийн аль нэгээр буюу эсхүл хослуулсан хэлбэрээр нийтийн зарыг түгээнэ.
- 25.4 Нийтийн зарыг тодорхой салбарын гишүүд, эсхүл намын бүтцийн байгууллагад сонгогдсон гишүүдийн хүрээнд түгээхдээ энэ дүрмийн 25.3-т заасан хэлбэрээр зар

түгээсэн эсэхээс үл хамааран намын апп-д бүртгүүлсэн имэйл хаяг руу захидал бичих, утасны дугаарт мессеж илгээх, утсаар ярих, цахим группт зар түгээх, биечлэн уулзаж зарлах хэлбэрээс дор хаяж хоёр хэлбэрийг ашигласан бол гишүүнд зарыг хүртээмжтэй хүргэсэн гэж үзнэ.

25.5 Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол намын гишүүнд нийтийн зарыг хүртээмжтэй хүргэсэн тохиолдолд намын аливаа хурлыг ирсэн ирцээр хуралдуулна. Ирсэн ирц гэж биечлэн танхимд ирсэн хүний тоо, цахимаар холбогдож оролцсон хүний тоо, намын албан ёсоор хэрэглэж буй цахим систем ашиглан саналаа өгсөн хүний тооны давхардаагүй нийлбэрийг хэлнэ.

25.6 Хэрэв хуралд оролцвол зохих гишүүнд зарыг хүртээмжтэй хүргээгүй нь тогтоогдвол дараах арга хэмжээний аль нэгийг авна:

25.6.1 Хурлыг ирсэн ирцээр эхлүүлж, хурлын зар бүрэн хүрээгүй шалтгааныг зар аваагүй хүн нэг бүр дээр дурдаж тэмдэглэл хөтлөн бүртгэлийн үнэн зөв байдлыг тодруулахаар Бүртгэгчид хүргүүлэх;

25.6.2 Хурлыг нэг удаа хойшлуулж, зарыг бүрэн хүргэх арга хэмжээг авах;

25.7 Намын дотоод сонгууль, намын хурлын шийдвэрийн санал хураалт нь цахим систем ашиглан, цаасаар, гар өргөж саналаа өгөх гэсэн горимын аль нэгээр явагдана.

25.8 Хурлын шийдвэр, сонгуулийн үр дүн нь санал хураалтад оролцсон гишүүдийн энгийн олонхын саналаар батлагдана.

25.9 Санал хураалт нь цахим систем ашиглах, цаасаар санал хураалт явуулах горимоор хэрэгжиж байгаа тохиолдолд уг санал хураалтыг зохион байгуулж буй этгээд санал хураалтад оролцох эрх бүхий гишүүдэд саналаа урьдчилж өгөх боломж гаргана.

25.10 Энэ дүрмийн 25.9-д заасан урьдчилсан санал хураалт нь дотоод сонгууль, хурлын товлосон хугацаанаас 72 хүртэлх цагийн өмнө эхэлж, санал хураалт хаах хүртэл үргэлжилж болно.

25.11 Энэ дүрэмд тусгайлан зааснаас бусад тохиолдолд намын хурлыг товлон зарласан албан тушаалтан, гишүүн удирдана.

26 **дугаар зүйл. Намыг өөрчлөн байгуулах, татан буулгах, өөр намтай нэгдэх, намын салбарыг татан буулгах**

26.1 Намыг өөрчлөн байгуулах, татан буулгах, өөр намтай нэгдэх талаар намын гишүүний бичгээр гаргасан саналыг тухайн санал гаргах өдрийн байдлаар намд бүртгэлтэй гишүүдийн 10-аас доошгүй хувь нь гарын үсэг зурж дэмжсэн бол Намын дарга ээлжит бус их хурал зарлан хуралдуулна.

26.2 Энэ дүрмийн 26.1-д заасны дагуу хуралдсан Намын Их Хурлын төлөөлөгчдийн тавны дөрвийн саналаар намыг өөрчлөн байгуулах, татан буулгах, өөр намтай нэгдэх эсэх асуудлыг шийднэ.

26.3 Нам нь үзэл баримтлал, үнэт зүйлийн давхцалын хувьд 80% -д, дотоод ардчилал ил тод байдал нь ойролцоо буюу ижил түвшинд хүрээгүй аливаа намтай нэгдэхгүй.

26.4 Энэ дүрмийн 26.1, 26.2-т заасны дагуу өөр намтай нэгдэх асуудлыг ээлжит бус их хурлаар Намын дарга хэлэлцүүлэхдээ намын нэр, билэгдэл, намын дүрмийн өөрчлөлтийн гол агуулгын талаар нэгдэхээр төлөвлөж буй намтай (намуудтай) хэрхэн зөвшилцсөн тухай мэдээлэл, холбогдох бичиг баримтыг хуралд танилцуулна.

26.5 Намын салбар бүхий сум, хорооны бүх гишүүд намын бүртгэлээс хасагдсан бол Бүртгэгч энэ тухай Намын даргад мэдэгдэж “салбар татан буулган тухай” хүсэлт бичгээр гаргана. Бүртгэгчийн хүсэлт, мэдээллийг үндэслэж намын салбарыг татан буулгах тухай тушаалыг намын дарга гаргана.

26.6 Намын танхим бүхий аль нэг аймаг, дүүрэгт байгуулагдсан бүх салбар татан буугдсан бол тухайн аймаг, дүүргийн танхимыг, нийслэлийн бүх дүүрэгт намын танхим татан буугдсан бол нийслэлийн танхимыг татан буулгах тушаалыг намын дарга гаргана.

26.7 Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах, өөр байгууллагатай нэгдэх шийдвэрийг тус байгууллагын дүрмээр зохицуулна. Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага өөрөө татан буугдсан бол энэхүү дүрмийн дагуу байгуулагдсан бодлогын судалгааны байгууллагыг нам шинээр байгуулж бүртгэж авна.

27 **дугаар зүйл. Дүрэм хүчин төгөлдөр болох**

27.1 Энэхүү дүрмийг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны дотор Улсын Дээд Шүүхэд бүртгүүлэхээр хүргүүлэх бөгөөд Улсын Дээд Шүүх улсын бүртгэлд бүртгэж авмагц хүчин төгөлдөр болно.

27.2 Энэхүү Дүрмийг Монгол хэлээр 2 эх хувь үйлдэж, нэг хувийг Монгол Улсын Дээд шүүхэд хадгалуулав.

27.3 Дүрмийн нэг эх хувийг “Монгол Улсын Дээд Шүүх”-д бүртгэсний дараа нөгөө эх хувиас уйгуржин монгол бичигт хөрвүүлэх, баррель үсгээр хэвлэх, сонсдог эх хувь бэлтгэх, англи хэл рүү орчуулах ажлыг тус тус Намын Ажлын Алба хариуцаж зохион байгуулна.